



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/1/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа Утас: 70584207 Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл
ДОА	Дорнод аймаг



	Агуулга
Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	122
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined. 4



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.12 № 46

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.МӨНХГЭРЭЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

2020.02.12 №46

D: Mv computer – TOOT A4

110519527



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв. Дорнод аймгийн Халамжийн сангаас 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/58 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино."

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Нийгмийн халамжийн хөнгөлөлт, тусламжийг нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд чанартай шуурхай хүргэх”

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, Дорнод аймгийн Халамжийн сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Халамжийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Халамжийн сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 13,085,195.1 мянган төгрөгөөс тооцон 261,703.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 268,788.2 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,511.9 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	60,3	3572,2	3511,9
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Хуримтлагдсан элэгдэл			
Нийт хөрөнгө	60,3	3572,2	3511,9
Өр төлбөр	135317,7		-135317,7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-135257,4	3572,2	3511,9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	60,3	3572,2	3511,9

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь банкны дансны үлдэгдэлд бодогдсон хүү, цалинтай ээжийн олгогдоогүй тэтгэмжийн үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Энэ нь тайлант үеийн үр дүнг өсгөж засгийн газрын оролцоо дансыг нэмэгдүүлсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орлого бүрдүүлдэг байгууллага биш тул орлогын төлөвлөгөө тусгагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулан 13,545,245.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 13,545,245.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 13,362,065.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 183,180.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төлөвлөжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 99.2 хувьтай байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүлжээ.



Аудитаар нийт 9,769.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,572.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6,197.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 9,769.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3,572.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.. Үүнд:

1. Тайлант оны харилцах дансны үлдэгдэл 3,572,219.06 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 45.2 дахь “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:”, 45.2.2 дахь “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл,” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байдал, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүтгэлийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Аймгийн ХХҮГ-ын ахмадын сувиллын хөнгөлөлтийн 6197,0 мянган төгрөгийн анхан шатны баримтыг бүрэн хавсаргаагүй байна.

1.2 Эрсдэл: Зориулалт бус зардал гарах.

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	60 251,21	3 572 219,06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	60 251,21	3 572 219,06



**Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

312	Банкинд байгаа бэлэн мөнгө	60 251,21	3 572 219,06
3121	Төгрөг	60 251,21	3 572 219,06
31213	Арилжааны банк дахь харилцах	60 251,21	3 572 219,06
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	60 251,21	3 572 219,06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	135 317 670,00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	135 317 670,00	-
413	Өглөг	135 317 670,00	-
4136	Бусад өглөг	135 317 670,00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	135 317 670,00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	- 135 257 418,79	3 572 219,06
51	Засгийн газрын хувь оролцоо	- 135 257 418,79	3 572 219,06
512	Хуримтлагдсан үр дүн	- 135 257 418,79	3 572 219,06
51210	Өмнөх үеийн үр дүн	- 182 917 411,11	- 135 257 418,79
51220	Тайлант үеийн үр дүн	47 659 992,32	138 829 637,85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	60 251,21	3 572 219,06

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13 132 855 059,35	13 578 239 349,12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15 901 859,35	32 993 815,12
120	Нийтлэг татварын бус орлого	15 901 859,35	32 993 815,12
120002	Хүүгийн орлого	13 767 784,35	16 227 481,12
120009	Бусад орлого	2 134 075,00	16 766 334,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13 116 953 200,00	13 545 245 534,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4 154 200 000,00	13 362 065 534,00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	4 154 200 000,00	13 362 065 534,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	8 962 753 200,00	183 180 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	8 962 753 200,00	183 180 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13 085 195 067,03	13 439 409 711,27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13 085 195 067,03	13 439 409 711,27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44 579 690,00	5 456 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44 579 690,00	5 456 400,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39 248 740,00	5 456 400,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5 330 950,00	5 456 400,00



**Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 040 615 377,03	13 433 953 311,27
2132	Бусад урсгал шилжүүлэг	12 934 439 273,57	13 236 676 268,00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	12 431 839 273,57	12 713 864 658,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	502 600 000,00	522 811 610,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29 192 707,40	191 541 873,27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29 192 707,40	191 541 873,27
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	76 983 396,06	5 735 170,00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	76 983 396,06	5 735 170,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	47 659 992,32	138 829 637,85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	47 659 992,32	138 829 637,85

/төгрөг/

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	13 163 059 927,78	13 578 239 349,12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46 106 727,78	32 993 815,12
120	Нийтлэг татварын бус орлого	46 106 727,78	32 993 815,12
120002	Хүүгийн орлого	13 767 784,35	16 227 481,12
120009	Бусад орлого	32 338 943,43	16 766 334,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13 116 953 200,00	13 545 245 534,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4 154 200 000,00	13 362 065 534,00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	4 154 200 000,00	13 362 065 534,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	8 962 753 200,00	183 180 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	8 962 753 200,00	183 180 000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	13 181 375 695,46	13 574 727 381,27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13 181 375 695,46	13 574 727 381,27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44 579 690,00	5 456 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44 579 690,00	5 456 400,00



**Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39 248 740,00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5 330 950,00	5 456 400,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 136 796 005,46	13 569 270 981,27
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	13 030 619 902,00	13 371 993 938,00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	12 534 439 902,00	12 849 253 938,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	496 180 000,00	522 740 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29 192 707,40	191 541 873,27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29 192 707,40	191 541 873,27
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	76 983 396,06	5 735 170,00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	76 983 396,06	5 735 170,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	= 18 315 767,68	3 511 967,85
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	- 18 315 767,68	3 511 967,85
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18 376 018,89	60 251,21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60 251,21	3 572 219,06

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			0,00	0,00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	0,00	0,00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0,00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0,00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
Тайлант үеийн үр дүн			47 659 992,32	47 659 992,32



Дорнод аймгийн Халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	0,00	0,00
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0,00	0,00	-135 257 418,79	-135 257 418,79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-135 257 418,79	-135 257 418,79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	-135 257 418,79	-135 257 418,79
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0,00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0,00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0,00
Тайлант үеийн үр дүн			138 829 637,85	138 829 637,85
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	3 572 219,06	3 572 219,06

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		60251,21
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13545245534,00	13377450338,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13545245534,00	13377450338,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9700000,00	5456400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9700000,00	5456400,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9700000,00	5456400,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13535545534,00	13371993938,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13535545534,00	13371993938,00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13535545534,00	13371993938,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13545245534,00	13545245534,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13545245534,00	13545245534,00

